



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ
УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ, ТАРИФЫН БУС БУСАД ХЯЗГААРЛАЛТ
ТОГТООХ БҮЛЭГ БАРААНЫ ЖАГСААЛТЫГ БАТЛАХ ТУХАЙ**

1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 05

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь :

1. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтыг 1 дүгээр хавсралт, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолоор баталсан улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны нэр төрлийг нарийвчлан гаргаж, Гаалийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн кодод оруулан батлах эрхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т олгосугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ